



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот


Г  
Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед  
ажиллах баг томилох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь хэсэг, 8.1.13 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед ажиллах багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үйл ажиллагааны чиглэлийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед ажиллах багийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Бямбадорж/-д даалгасугай.
3. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед ажиллах багийг холбогдох мэдээллээр хангаж, хамтран ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.
4. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед ажиллах Шүүрхай хариу арга хэмжээний багийн гишүүдийн цалин, илүү цагийн хөлсийг холбогдох хууль, журмын дагуу тооцож олгохыг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /Ш.Энхтөр/, Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/-д тус тус үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.

САЙД

ДСАРАНГЭРЭЛ



080039



**ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТИЙН ҮЕД  
АЖИЛЛАХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

**1. Төлөвлөлт, зохицуулалтын баг:**

- Ахлагч: Б.Бямбадорж, ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга
- Нарийн бичгийн дарга: У.Цэвэгмид, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /ЭХЭМҮТ/-ийн Хүүхдийн зөвлөх поликлиникийн эрхлэгч
- Гишүүд:  
Р.Оюунханд, ЭМЯ-ны Еодлого төлөвлөлтийн газрын дарга  
Б.Цогтбаатар, ЭМЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга  
М.Баттүвшин, ЭМЯ-ны Эмнэлгийн т/сламжийн газрын дарга  
Т.Энхзаяа, ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга  
Д.Нарангэрэл, ЭМЯ-ны Олон нийттэй харилцах тандалт шуурхай удирдлагын хэлтсийн дарга  
Д.Нарантуяа, ЭМЯ-ны Эдийн засаг санхүүгийн хэлтсийн дарга  
Г.Эрдэмбилэг, ЭМЯ-ны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга  
Г.Ганхуяг, ЭМЯ-ны Эрүүл мэндийн дээдтээгүүдийн бодлогын хэлтсийн дарга  
Л.Төмөрбаатар, ЭМЯ-ны Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга

**2. Шуурхай хариу арга хэмжээний баг**

- Ахлагч: У.Цэвэгмид, ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн зөвлөх поликлиникийн эрхлэгч
- Гишүүд:  
М.Оюун, Халдварт өвчин судлалын үндэсний төв /ХӨСҮТ/-ийн Дархлаажуулалтын албаны тархваас судлагч  
Т.Оюун-Эрдэнэ, ХӨСҮТ-ийн Томуугийн үндэсний нэгжийн тархвар судлагч  
Б.Бадамням, ЭХЭМҮТ-ийн Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн

3. Эмнэлзүйн баг:

- Ахлагч: М.Наранпүрэв, Анагаах ухааны үндэсний их сургуулийн Эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэлтийн тэнхимийн багш
- Гишүүд: Д.Чулуунбаатар, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн дарга  
Ц.Төмөр-Очир, Улсын гуравдугаар төв эмнэлгийн дарга  
Ш.Энхтөр, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал  
Д.Нямхүү, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал  
Ц.Ганбат, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч, зөвлөх эмч

4. Эрсдэлийн харилцаа холбооны баг:

- Ахлагч: Д.Нарангэрэл, ЭМЯ-ны Олон нийттэй харилцах тандалт шуурхай удирдлагын хэлтсийн дарга
- Гишүүд: Н.Отгонжаргал, ЭМЯ-ны ОНХТШУХ-ийн мэргэжилтэн  
Т.Амаржаргал, ЭМЯ-ны ОНХТШУХ-ийн мэргэжилтэн  
Н.Сувдмаа, ХӨСҮТ-ийн Эрт сэрэмжлиүүлэг хариу арга хэмжээний нэгжийн дарга  
С.Гэрэлмаа, НЭМҮТ-ийн Эрүүл мэндийг дэмжих албаны дарга  
А.Бурмаа, ХӨСҮТ-ийн Томуугийн үндэсний нэгжийн дарга  
Ч.Уртнасан, ХӨСҮТ-ийн Томуугийн үндэсний нэгжийн тархвар судлагч

5. ЭМЯ-аас дэмжлэг үзүүлэх баг:

- Ахлагч: З.Балдандугар, Уламжлалт анагаах ухааны хэлтсийн дарга
- Гишүүд: Я.Болормаа, Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн  
Н.Цогзолмаа, Бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн  
А.Бархас, Эмнэлгийн тусlamжийн газрын мэргэжилтэн  
Э.Оюунсүрэн, Эм, үйлдвэрлэл, технологийн газрын мэргэжилтэн  
Д.Байгалмаа, Нийгмийн эрүүл мэндийн газрын мэргэжилтэн  
Э.Мөнхмандах, Эдийн засаг санкүүгийн хэлтсийн мэргэжилтэн  
Т.Болорчимэг, Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн

Эрүүл мэндийн даидын 2019  
оны 16 дугаар сарын 16.  
өдрийн 16 дугаар тушаалын 2  
дугаар хавсралт

## ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТИЙН ҮЗД АЖИЛЛАХ БАГИЙН ЧИГ ҮҮРЭГ

### 1. Төлөвлөлтийн баг:

- 1.1. Хариу арга хэмжээний ерөнхий удирдлагыг ханган, багуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулна.
- 1.2. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний богино, дунд, урт хугацааны төлөвлөгөө гаргана.
- 1.3. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед шаардагдах 500 орны тооцоолол, судалгааг гарган Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлнэ.
- 1.4. Улирлын томуугийн эсрэг вакцин, эм бэлдмэлийн тооцоог гарган шийдвэрлэнэ.
- 1.5. Томуу, томуу төст өвчний улирлын үед шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийг тооцоо судалгаанд тулгуурлан шийдвэрлэнэ.
- 1.6. Хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай шийдвэрийг шуурхай гаргана.
- 1.7. Томуу, томуу төст өвчний тархвар зүйн төлвөөс шалтгаалан дэгдэлтийн үед ажиллах Шуурхай хариу арга хэмжээ, эрсдэлийн харилцаа холбооны багийн үйл ажиллагааг цуцална.

### 2. Шуурхай хариу арга хэмжээний баг

- 2.1. Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, тусгай эмнэлэг, аймаг, нийслэлийн ЭМГ, хувийн хэвшлийн ортой эмнэлгээс дараах мэдээллийг амралтын өдрийг оролцуулан өдөр бүр 07:00-08:00 цагийн хооронд авч нэгтгэнэ (Утас: 261629, 95958458, 95958315, 95958316, 95958317, flutearn2019@gmail.com). Үүнд:

- 2.1.1. Орны ачаалал: батлагдсан, нэмэлтээр зохицуулсан, дэлгэсэн, эрчимт эмчилгээний орны тоог хүүхэд, насанд хүрэгчдээр;
- 2.1.2. Тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа нийт өвчтөний тоо, үүнээс амьсгалын замын цочмог хүнд халдвартай өвчтөний тоо, насны бүлгээр;
- 2.1.3. Тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа жирэмсэн эмэгтэйн тоо, үүнээс амьсгалын замын цочмог хүнд халдвартай жирэмсэн эмэгтэйн тоо, насны бүлгээр;
- 2.1.4. Эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж байгаа өвчтөний тоо, насны бүлэг, Олон улсын өвчний 10 дугаар ангиллаар;
- 2.1.5. Яаралтай тусlamжийн тасгийн үзлэгийн тоо, үүнээс томуу томуу төст өвчний үзлэгийн тоо, насны бүлгээр;

2.1.6. Түргэн тусламжийн дуудлагын тоо, үүнээс томуу томуу төст өвчний шалтгаант дуудлагын тоо, насны бүлгээр;

2.1.7. Нас баралтын тоо, үүнээс амьсгалын замын хүнд халдвартын шалтгаантай нас баралтын тоо, Олон улсын өвчний 10 дугаар ангиллаар, насны бүлгээр.

2.2. Томуугийн өвчлөл, амбулаторийн үзлэгийн мэдээг өдөр бүр 09:00 цагт ХӨСҮТ-ийн Томуугийн үндэсний нэгжээс авч нэгтгэнэ.

2.3. Томуугийн вирус судлалын лабораторийн мэдээг 7 хоногийн мягмар, баасан гараг бурийн 11:00 цагт ХӨСҮТ-ийн Томуугийн үндэсний нэгжээс авч нэгтгэнэ.

2.4. Өдөр тутмын шинэчлэгдсэн мэдээллийг 10:00 цагт нэгтгэн төлөвлөлтийн багт цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2.5. Нөхцөл байдлын мэдээлэлд дүн шинжилгээ хийн, мэргэжил аргазүй, удирдлагаар хангана.

2.6. Амьсгалын замын цочмог хүнд халдвартай өвчтөний оногилгоо, эмчилгээнд телемидицинээр зөвлөгөө өгөх, хүнд өвчтөнийг эмнэлэг хооронд тээвэрлэх асуудлыг зохицуулна.

2.7. Өдөр бүр 07 цагаас 22 цагийн хооронд хуваарийн дагуу ажиллана.

### 3. Эмнэлзүйн баг

3.1. Томуу, томуу төст өвчний үеийн тусламж үйлчилгээний зохион байгуулалтын зураглал гаргах

3.2. Томуу, томуу төст өвчний эмнэлзүйн удирдамж, амьсгалын замын цочмог халдвартай жирэмсэн эмэгтэйчүүдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний зөвлөмж, эмчилгээний загвар гаргах

3.3. Халдвараас сэргийлэх дэглэм, эмчилгээний зардлыг тооцоолон, загвар гаргана

3.4. Амьсгал удирдах, ТТӨ-ний эмнэлзүйн удирдамжаар сургалт зохион байгуулна.

### 4. Эрсдэлийн харилцаа холбооны баг:

4.1. Нөхцөл байдлын талаарх мэдээллийг олон нийтэд тухай бүрд шуурхай өгнө.

4.2. Цаг үеийн асуудлаар хэвлэлийн бага хурал зохион байгуулна.

4.3. Олон нийтэд зориулсан мэдээ, мэдээлэл, зөвлөмж болоцруулан түгээнэ.

4.4. Сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулна.

4.5. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээний мэдээлэлд тандалт хийж, холбогдох арга хэмжээг шуурхай авна.

### 5. Өндөржүүлсэн бэлэн байдлын баг

5.1. Шаардлагатай үед уртасгасан цагаар нэмэлтээр ажиллана.

5.2. Холбогдох арга хэмжээний төсөв тооцоог гарган, шийдвэрлүүлнэ.

5.3. Холбоо зарлан мэдээллийг хариуцан ажиллана.

5.4. Дээрх багуудын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.